

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙД,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар А-368/302

Улаанбаатар хот

"Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний 1 га талбайн
зардлын нормативыг шинэчлэн батлах тухай"

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.24, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний 1 га талбайн зардлын нормативийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэхэд мөрдөх, төсөвт байгууллагууд зардлыг батлагдсан төсөвт багтаан эжиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Гантулга/, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний 1 га талбайн зардлын нормативыг шинэчлэн тогтоох тухай" Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2009 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 158/154 дугаар тушаал, "Зардлын норматив батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А-59 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй



Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын

хамтарсан 2012 оны 12 сарын 25 өдрийн

дугаар тушаалын хавсралт

ОЙЖУУЛАЛТ, ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЗАРДЛЫН НОРМАТИВ

№	Ойн аж ахуйн арга хэмжээний нэр	Хэмжих нэгж	Зардлын хэмжээ /төг/
1	Ойт хээрийн бүс	Тарьцаар ойжуулах ажил	га 695,000.0
		Суулгацаар ойжуулах ажил	га 1,050,000.0
2	Тал хээр, цөлөрхөг хээр, цөлийн бүс	Тарьцаар ойжуулах ажил	га 784,000.0
		Суулгацаар ойжуулах ажил	га 905,000.0
		Ойн зурвас байгуулах ажил	га 2,000,000.0
3	Үрээр ойжуулах ажил	Шилмүүст модны үрээр	га 300,000.0
		Загийн үрээр	га 400,000.0
4	Байгалийн аясаар сэргэн ургалтыг дэмжих ажил	га 200,000.0	
5	Үр түүх түр болон байнгын талбай тусгаарлах ажил	га 595,000.0	
6	Худалдаж авах таримал ой	га 1,000,000.0	
7	Тарьц ургуулах ажил	Шилмүүст модны стандартын тарьц	мян.шир 150,000.0
		Заг болон бусад навчит модны стандартын тарьц	мян.шир 165,000.0
8	Суулгац ургуулах ажил	Шилмүүст модны стандартын суулгац	мян.шир 650,000.0
		Заг болон бусад навчит модны стандартын суулгац	мян.шир 700,000.0
9	Ойн бүртгэл тооллого, ой зохион байгуулалтын ажил	га 350.0	
10	Ойн арчилгааны огтлолт хийх ажил	га 120,000.0	
11	Ойн цэвэрлэгээний огтлолт хийх ажил	га 20,000.0	
12	Мод бэлтгэлийн талбай тусгаарлах ажил	га 25,000.0	
13	Түймрээс урьдчилан, хамгаалах ажил	Халз зурвас байгуулах	га 2,000,000.0
		Шороон зурвас байгуулах	га 230,000.0
14	Агаарын хөлгөөр ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил	Авирахимийн арга	га 11,500.0
		Авиамикробиологийн арга	га 50,000.0
		Өвчинтэй тэмцэх	га 38,000.0
15	Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багажаар тэмцэх ажил	Химийн арга	га 8,900.0
		Микробиологийн арга	га 48,400.0
16	Механик аргаар тэмцлийн ажил явуулах	га 5,000.0	
17	Ойн хөнөөлт шавжтай бусад аргаар тэмцэх ажил	Гэрлэн урхи тавих	га 11,000.0
		Бүслүүрийн аргаар ойн хөнөөлт шавжтай тэмцэх	га 50,000.0
		Модонд тариа тарих	га 65,000.0